



ДОРНОГОВЬ АЙМАГ
АЙРАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/52

Цагаандөрвөлж

Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага
худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.17 дахь заалт, 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн “Улсын хэмжээнд 2026 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил хэмжээ, зориулалтын жагсаалт” 45 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/188 дугаар “Аргачлал шинэчлэн батлах тухай” тушаал, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн “Газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөө батлах тухай” 07/35 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөөний дагуу хавсралтад дурдагдсан газруудад эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдааг зохион байгуулсугай.

2.Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг зохих журмын дагуу 2026 оны 05 дүгээр сарын 20-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулахыг Газрын даамал (Т.Золбоо)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Туул)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.ГАНБААТАР



Айраг сумын Засаг даргын 026-оны
04. дүгээр сарын 14 өдрийн АЗС дугаар
захирамжийн хавсралт

**ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЖУРМААР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ,
ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ЗАРЛАХ ҮНЭ**

Д/д	Баг	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Газрын байршил	Газрын хэмжээ (м2)	Газрын зориулалт	Дуудлага худалдааны анхны үнэ (төгрөг)	Дэнчингийн хэмжээ (төгрөг)
1	1-р баг	4870324	Хонгорын уурхайгаас Баруун цагаан дэл хүртэл	996206	Цэвэр ус дамжуулах хоолой	19,924,120	1,992,412
2	1-р баг	4870325	Хонгорын уурхайгаас Цагаандэл хүртэл	609115	Цэвэр ус дамжуулах хоолой	12,182,300	1,218,230
Нийт				1605321		32,106,420	

_____ 0-0-0 _____